

САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр
Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, биеэ үнэлж, явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Садар самуун явалдахтай тэмцэх тухай хууль тогтоомж

2.1. Садар самуун явалдахтай тэмцэх тухай хууль тогоомж нь Эрүүгийн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2 Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "садар самууныг сурталчлах" гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг;

3.1.2. "садар самуун явалд" гэж биеэ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг;

3.1.3. "эротик" гэж гоо сайхны таашаал төрүүлэх зорилгоор хүний нүцгэн биеийг урлаг, уран сайхны хэлбэрээр үзүүлэхийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

САДАР САМУУН ЯВДЛЫГ ХОРИГЛОХ

4 дүгээр зүйл. Биеэ үнэлж явалдах, биеэ үнэлэхийг зохион байгуулахыг хориглох

4.1. Биеэ үнэлж явалдахыг хориглоно.

4.2. Биеэ үнэлж явалдах нөхцөлөөр хангаж, зочид буудлын өрөө, гэр, орон сууц, тусгай байр, тээврийн хэрэгслээр зориуд үйлчлэх, зуучлахыг хориглоно.

5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох

5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хоиглоно.

5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

5.3. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Садар самуун явалдахтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

6.1. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон эрүүл мэнд, хэвлэл, мэдээлэл, гэгээрлийн байгууллагууд садар самуун явалдлын хор үршгийг олон нийтэд ойлгуулан таниулах,

14 дүгээр зүйл. Хуулийн заалтыг дагаж мөрдөх журмын тухай

14.1. Энэ хуулийн 6.2-т заасныг 1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ